



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/272

Улаанбаатар хот

"Их нүүдэл" шатрын хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.24 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 01/188 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Их нүүдэл" шатрын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан хөтөлбөрийг 2026–2027 оны хичээлийн жилд эхлүүлж, үе шаттай өргөжүүлэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар (Л.Ганбат)-т, Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (Х.Отгонбаатар)-д, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (В.Түвшинжаргал)-т даалгасугай.

САЙД



Д.ЭНХ-АМГАЛАН

1426010770

Боловсролын сайдын
2026 оны 08 дугаар сарын 08 ны өдрийн
А/242 дугаар тушаалын хавсралт



“ИХ НҮҮДЭЛ” ШАТРЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжил, дижитал орчны хэрэглээ нэмэгдэж буй өнөө үед бага ангийн суралцагчдын анхаарал төвлөрөл буурах, дижитал хамааралтай болох, шүүмжлэлт болон логик сэтгэлгээний чадамж сулрах эрсдэлүүд бий болж байна. Иймээс бага ангийн суралцагчдад шүүн тунгаах, бүтээлчээр сэтгэх, суралцахуйд суралцах, харилцах ба хамтран ажиллах болон нийгэм, сэтгэл хөдлөлийн ерөнхий болон суурь чадамжуудыг цогцоор нь олгоход суралцагчийн идэвхтэй оролцоо, туршилт, тоглоомд суурилсан сургалтын орчин нэн чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д оюунлаг, бүтээлч, үндэсний соёл, үнэт зүйлээ эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д суралцагчийн бүтээлчээр болон шүүн тунгаан сэтгэх, суралцахуйд суралцах, нийгэм-сэтгэл хөдлөлийн хөгжил, үндэсний болон дэлхийн өв соёлын ерөнхий чадамжийг боловсролын түвшин бүрд залгамж холбоотой хөгжүүлэхээр тодорхойлсон.

Шатрын сургалтын үр нөлөөг судалсан олон улсын судалгаагаар хүүхдийн танин мэдэхүйн болон академик зарим чадварт эерэг нөлөө үзүүлэх боломжтой боловч үр дүн нь сургалтын хугацаа, арга зүй, хөгжүүлэхээр зорьсон чадвартай хэрхэн уялдуулснаас хамаардаг болохыг тэмдэглэсэн байна. Иймд шатрын сургалтыг бусад хичээлийн амжилтыг нэмэгдүүлэх хэрэгсэл гэж үзэхээс илүүтэй суралцагчийн ажиглах, шинжлэх, хувилбар боловсруулах, тооцоолох, сонголт хийх, шийдвэр гаргах, алдаанаасаа суралцах үйл ажиллагааг тогтмолжуулах сургалтын орчин болгон ашиглах нь зүйтэй. Сургуулийн насны хүүхдүүдийг хамруулсан судалгаанд шатар тоглодог хүүхдүүд төлөвлөлтийн зарим үзүүлэлтээр харьцангуй сайн гүйцэтгэл үзүүлсэн нь шатрын сургалтыг эдгээр чадварыг дадлагажуулах сургалтын орчин болгон ашиглах боломжтойг харуулж байна.

Шатрыг боловсролын зорилгоор ашиглах туршлага олон улсын хэмжээнд өргөжин хөгжиж байна. Европын Парламент 2012 онд “Chess in School” санаачилгыг дэмжсэн бөгөөд Олон улсын шатрын холбоо (FIDE) шатрыг хүүхдийн танин мэдэхүй, суралцахуй, нийгэм-сэтгэл хөдлөлийн хөгжлийг дэмжих боловсролын хэрэглэгдэхүүн болгон ашиглах чиглэлийг хөгжүүлж байна. Казахстан Улсад 1–4 дүгээр ангийн сурагчдад зориулсан “Шатрын үндэс” хөтөлбөрийг хэрэгжүүлж,

шатрын суурь мэдлэг, дүрэм, нүүдлээс эхлэн тоглох арга ухаан, чадварыг үе шаттай хөгжүүлж байгаа нь энэхүү сургалтыг системтэй хэрэгжүүлэх боломжийг харуулж байна.

Монгол Улсад шатрын сургалтын агуулга, арга зүйг бага боловсролын түвшинд хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 1-5 дугаар ангийн 26 бүлгийн 1178 сурагчийг хамруулан 2026.05.01-06.12-ны хооронд туршилтын сургалт зохион байгуулсан. Туршилтын явц, суралцагчдын оролцоо, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн шатрын сургалтыг бага ангийн сурагчдын хөгжлийн онцлогт нийцүүлэн тоглоом, дасгал, бодлого, практик тоглолтод суурилан зохион байгуулж, анги ахих бүрд агуулга, чадварын түвшнийг залгамж холбоотойгоор ахиулах боломжтой гэж үзсэн болно.

Иймээс Монгол Улсын боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, суралцагчдын нас, хөгжлийн онцлог, шатрын боловсролын олон улсын судалгаа, туршлага, Монгол шатрын өв соёл болон туршилтын сургалтын үр дүнд үндэслэн үе шаттайгаар хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.

Хөтөлбөр нь суралцагчдад шатрын суурь мэдлэг, тоглох чадварыг залгамж холбоотой эзэмшүүлэхийн зэрэгцээ бүтээлчээр болон шүүн тунгаах, асуудал шийдвэрлэх, төлөвлөх, үндэслэлтэй шийдвэр гаргах, өөрийгөө зохицуулах, шударгаар өрсөлдөх, үндэсний болон дэлхийн шатрын өв соёлыг танин мэдэх чадвар, хандлагыг хөгжүүлэхэд чиглэнэ.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ХАМРАХ ХҮРЭЭ, ҮР ДҮН

"Их нүүдэл" шатрын хөтөлбөрийг Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн 1–12 дугаар ангид дараах үе шаттай хэрэгжүүлнэ.

Үе шат	Хугацаа /хичээлийн жилээр/	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
I шат	2026–2027	Ерөнхий боловсролын сургуулийн бага (I-V) анги
II шат	2027–2028	Ерөнхий боловсролын сургуулийн дунд (VI-IX) анги
III шат	2028–2029	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах (X-XII) анги

Хүлээгдэх үр дүн

1. Шатрын сургалт нь ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагааны хэсэг болж, төлөвшсөн байна.

2. Суралцагчдын логик, стратегийн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, өөрийгөө удиррдах, бусдад хүндэтгэлтэй хандах чадвар, хандлага, төлөвшилд ахиц гарсан байна.

3. Багшийн арга зүйн чадавх, сургалтын хэрэглэгдэхүүний суурь орчин сайжирсан байна.

4. Монголын шатрын уламжлал, оюуны өвийн талаарх хүүхдийн мэдлэг нэмэгдсэн байна.

Хэрэгжүүлэгч, хамтран ажиллах, оролцогч талууд

Хэрэгжүүлэгч: Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын сургууль.

Хамтран ажиллагч: Монголын шатрын холбоо, сургуулиудын шатрын холбоо, орон нутгийн төр, захиргааны байгууллагууд, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, төр хувийн хэвшлийн бусад байгууллагууд

Оролцогч: Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч, иргэд, олон нийт.

ГУРАВ. ШАТРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Шатар нь дүрэм, зорилго, орон зайн бүтэц, олон хувилбарт сонголт, төлөвлөлт, шийдвэрийн үр дагаврыг нэг дор агуулсан оюуны тоглоом бөгөөд сурагчийг нөхцөл байдлыг ажиглах, боломжит хувилбарыг тодорхойлох, харьцуулах, урьдчилан тооцоолох, үндэслэлтэй шийдвэр гаргах, гаргасан шийдвэрээ эргэн шинжлэх үйл ажиллагаанд тогтмол оролцуулдаг. Иймээс шатрын сургалт нь шатрын суурь мэдлэг, тоглох чадварыг эзэмшүүлэхийн зэрэгцээ бага боловсролын хөтөлбөрт тусгагдсан сурагчийн шүүн тунгаах, асуудал шийдвэрлэх, төлөвлөх, үндэслэлтэй сонголт хийх, өөрийн үйл ажиллагааг хянах, эргэцүүлэх чадварыг хөгжүүлэх боломжтой.

Монголчуудын уламжлалт хөлөгт тоглоомын нэг болох Монгол шатар нь нүүдэлчдийн ахуй, сэтгэлгээ, зан заншлын онцлогийг дүрсний нэршил, хийц, дүрслэл, тоглох ёс, уламжлалт хэллэгтээ хадгалан хөгжиж ирсэн. Монгол шатрыг тоглох уламжлалд тэвчээртэй байх, хийсэн сонголтдоо хариуцлагатай хандах, өрсөлдөгчөө хүндэтгэх, тоглоомын дэгийг сахих зэрэг хүмүүжлийн агуулга тусгалаа олсон байдаг. Тухайлбал, “нүүсэн бол буцахгүй”, “сандарвал өрөг алдана, зандарвал нөхөр алдана” зэрэг уламжлалт сургаал хэллэг нь шийдвэртээ хариуцлагатай хандах, тайван, тэвчээртэй байхыг сургамжилдаг. Мөн Монгол шатрын уламжлалт тоглох ёсны зарим хэлбэрт бэрсээр мэдлэхгүй байх хэм хэмжээг баримталж ирсэн нь давуу байдлаа зохистой хэрэглэх, өрсөлдөгчөө хүндэтгэх, хүч чадлаар бусдыг дорд үзэхгүй байх зэрэг ёс суртахууны агуулгатай холбон тайлбарлагддаг. Иймд Монгол шатрын уламжлалт тоглох ёс, нэршил, сургаал хэллэгийг сурагчийн нас, хөгжлийн онцлогт тохируулан сургалтын агуулгад тусгах нь өөрийн сэтгэл хөдлөлөө удирдах, шийдвэртээ хариуцлагатай хандах, бусдыг хүндэтгэх, шударга тоглох хандлагыг төлөвшүүлэхийн зэрэгцээ үндэсний өв соёлоо танин мэдэх, өвлөн уламжлах боломжийг бүрдүүлнэ.

ДӨРӨВ. ЗОРИЛГО

Шатрын хөтөлбөрийн зорилго нь сурагчдад шатрын суурь мэдлэг, тоглох чадвар эзэмшүүлж, бүтээлчээр шүүн тунгаах сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх, шударга, хүндэтгэлтэй харилцах хандлагыг төлөвшүүлэхэд оршино.

ЗОРИЛТ:

- 1) Шатрын хөлөг, дүрс, нүүдэл, тэмдэглэгээ, өрөг тоглох болон тэмцээний үндсэн дүрмийг эзэмшүүлэх;
- 2) Хөлөг дээрх байрлалыг ажиглах, мэдээллийг ялган таних, боломжит нүүдлийг тодорхойлох, хувилбарын үр дагаврыг урьдчилан тооцоолох чадварыг хөгжүүлэх;
- 3) Тоглох үндсэн хэв шинжийг таних, байрлалын хүчин зүйлсийг үнэлэх, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх чадварыг хөгжүүлэх;
- 4) Өөрийн нүүдэл, гаргасан шийдвэр, тоглолтын үр дүнг эргэн шинжлэх, алдаагаа илрүүлж засах, түүнээс суралцах арга барил эзэмшүүлэх;
- 5) Тоглолтын дүрэм, дэгийг сахих, цаг баримтлах, ялалт, ялагдлыг зөв хүлээн авах, өрсөлдөгчөө хүндэтгэх, шударга тоглох хандлагыг төлөвшүүлэх;
- 6) Монгол шатрын түүх, уламжлалт нэршил, дүрслэл, тоглох ёс, сургаал хэллэг танин мэдүүлэх.

ТАВ. БАГА АНГИЙН ШАТРЫН ХӨТӨЛБӨР:

5.1. Хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт	I-II анги	III-V анги
Шатрын хөлөг, дүрс, нүүдэл, тэмдэглэгээ, өрөг тоглох болон тэмцээний үндсэн дүрмийг эзэмшүүлэх;	Шатрын хөлөг, дүрсүүдийн нэр, анхны байрлал, нүүдэл, идэлт, шалах болон мэдлэх үндсэн дүрмийг танин мэдэж, хялбар өрөг тоглож сурах.	Шатрын тэмдэглэгээг бүрэн хэрэглэж өргөө бичих, шатрын цагтай тоглох, тэмцээний дүрмийг (барьсан бол нүүх гэх мэт) хатуу баримтлан бүтэн өрөг тоглох.
Хөлөг дээрх байрлалыг ажиглах, мэдээллийг ялган таних, боломжит нүүдлийг тодорхойлох, хувилбарын үр дагаврыг урьдчилан тооцоолох чадварыг хөгжүүлэх;	Хөлөг дээрх шууд аюулыг (дүрс рүү довтолсон байдал) олж харах, 1 нүүдлийн доторх ашигтай нүүдэл болон мэдлэх хувилбарыг тооцоолох	2-3 нүүдлийн цаадах хувилбаруудыг тооцоолох, өрсөлдөгчийнхөө далд санааг урьдчилан таамаглаж, олон хувилбараас оновчтойг нь сонгох.
Тоглох үндсэн хэв шинжийг таних, байрлалын хүчин зүйлсийг үнэлэх, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх чадварыг хөгжүүлэх;	Давхар цохилт, дараас, нээж шалах зэрэг 1 нүүдлийн энгийн аргуудыг таних, хэрэгжүүлэх. Төвөө эзлэх, дүрсээ гаргах анхан шатны ойлголттой байх.	Хамгаалалт устгах, өгөөш хаях зэрэг нийлмэл аргуудыг ашиглах. Байрлалаа үнэлж (нээлттэй шугам, ноёны байрлал) дунд болон төгсгөлийн тоглолтын төлөвлөгөө боловсруулах.
Өөрийн нүүдэл, гаргасан шийдвэр, тоглолтын үр дүнг эргэн шинжлэх, алдаагаа илрүүлж засах, түүнээс суралцах арга барил эзэмшүүлэх;	Тоглолтын дараа гаргасан алдаагаа (дүрсээ сул өгсөн, мэдлүүлсэн шалтгаан) багшийн чиглүүлгээр олж харах, дахин давтахгүй байхыг хичээх.	Өөрийн бичиж тэмдэглэсэн өргийг бие даан эсвэл багштай хамт эргэн шинжлэх (анализ хийх), алдааныхаа шалтгааныг олж тайлбарлах, түүнээс сургамж авах.

Зорилт	I–II анги	III–V анги
Тоглолтын дүрэм, дэгийг сахих, цаг баримтлах, ялалт, ялагдлыг зөв хүлээн авах, өрсөлдөгчөө хүндэтгэх, шударга тоглох хандлагыг төлөвшүүлэх;	Тоглолт эхлэх ба дуусахад гар барих, чимээгүй тоглох, барьсан дүрсээрээ заавал нүүх дүрмийг дадал болгох, хожигдлоо уурлахгүйгээр хүлээн авах.	Тэмцээний ёс зүйг дээдлэх, цагтай зөв харьцах, хожсон ч, хожигдсон ч өрсөлдөгчөө хүндэтгэн өргөө хамт шинжлэх, шударга өрсөлдөөнийг эрхэмлэх хандлагатай болох.

5.2. АГУУЛГЫН ХҮРЭЭ

Хүснэгт 1. Агуулгын залгамж холбоо

Агуулгын чиглэл	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
Шатрын хөлөг, дүрэм	Хөлөг, дүрсийг таних, зөв өрөх, дүрсийн нүүдлийг хийх	Шаг, мад, тэнцээ болон тусгай нүүдлийг таних	Үндсэн дүрмийг баримтлан бүтэн өрөг тоглох	Тоглолтын цаг, тэмцээний энгийн дүрмийг баримтлах	Дүрэм, дэгийг бие даан мөрдөж тоглох
Шатрын тэмдэглэгээ	Хөлгийн босоо, хэвтээ шугам, нүдийг нэрлэх	Дүрсийн тэмдэглэгээ, нүүдлийн энгийн бичлэгийг таних	Гол нүүдлээ тэмдэглэж, хялбар бичлэгийг унших	Богино өргийн тэмдэглэлийг уншиж, тоглох	Өөрийн тоглолтын үндсэн нүүдлийг тэмдэглэх
Тоглолтын хувилбар	Дүрс барих, хамгаалах, шаглах, нэг нүүдлийн мад хийх	Давхар цохилт, нээж шалах, дараас аргуудыг таних	Давхар цохилт, нээж шалах, дараас аргуудыг энгийн байрлалд хэрэглэх	Нэг, хоёр нүүдлийн тактикийн бодлого бодох	Сурсан тактикийн аргыг тоглолтод сонгон хэрэглэх
Тоглох арга ухаан	Төвийг эзлэх, дүрсээ хөгжүүлэх, ноёноо хамгаалах	Нээлтийн үндсэн зарчмыг таних	Дүрсээ зөв байрлуулж, хамгаалалтаа сайжруулах	Дүрсийн хүч, хамгаалалт, идэвхийг харьцуулах	Байрлалд тохирсон энгийн төлөвлөгөө гаргах
	Энгийн мадын байрлалыг таних	Ноён, Бэрс болон ноён, тэргээр мадлах	Ноён, хүүгийн энгийн төгсгөлийг тоглох	Хүүгээ бэрс гаргах аргыг хэрэглэх	Сурсан мад болон хүүгийн төгсгөлийн аргыг тоглолтод хэрэглэх
Тоглолтын үр дүн, шинжилгээ	Хялбаршуулсан богино тоглолт хийх	Энгийн бүтэн өрөг тоглож, үр дүнгээ ярилцах	Өөрийн тоглолтын зөв болон алдаатай нүүдлийг таних	Цаг, анхаарал, сэтгэл хөдлөлөө зохицуулан тоглох	Тоглолтоо эргэн харж, сайжруулах нэгээс хоёр арга тодорхойлох

НЭГДҮГЭЭР АНГИ: ШАТРЫН ЦАГААН ТОЛГОЙ

Суралцахуйн үр дүн	Жишиг үйл ажиллагаа
1.1 Шатрын хөлөг, дүрсийг таньж, зөв өрөн, дүрс бүрийн үндсэн нүүдлийг хийж харуулна.	Хөлгийн босоо, хэвтээ шугам болон нүдийг өнгө, тэмдэглэгээгээр нь олох. Дүрс бүрийн нүүх, идэх онцлогийг тоглоомын аргаар турших. Дүрсүүдийг анхны байрлалд зөв өрөх буухиа тоглоом тоглох.
1.2 Шаг, мад болон дүрсээ хамгаалах анхан шатны ойлголтыг энгийн байрлалд хэрэглэнэ.	Шаг ба мадын байрлалыг зэрэгцүүлэн ажиглаж, ялгааг тайлбарлах. Нэг нүүдэлд шаглах, мадлах хялбар бодлого бодох. Довтолгоонд өртсөн дүрсийг хамгаалах эсвэл аюулгүй нүдэнд шилжүүлэх.
1.3 Төв рүү нүүх, дүрсээ хөгжүүлэх, ноёноо хамгаалах энгийн зарчмыг дагаж тоглоно.	Төвийн дөрвөн нүдийг хөлөг дээр зааж, төв рүү хүүгээр нүүх. Морь, тэмээг эхний байрлалаас гаргах дасгал хийх. Ноёноо хамгаалалттай байлгахын ач холбогдлыг зурагт байрлал дээр ярилцах.
1.4 Энгийн мадын байрлал болон хүү сүүлчийн шугамд хүрч хувирах дүрмийг таньж хэрэглэнэ.	Бэрс, тэрэг оролцсон нэг нүүдлийн мадын байрлал олох. Хүүг сүүлчийн шугамд хүргэж сонгосон дүрсээр хувиргах. Мад эсэхийг хосоороо шалгаж, шалтгаанаа хэлэх.
1.5 Цөөн дүрстэй хялбаршуулсан тоглолтод дүрмээ баримтлан оролцоно.	Зөвхөн хүүгээр тоглож, эхэлж дүрс гаргасан тал хожих мини тоглолт хийх. Ноён, хүү болон нэг дүрс оролцсон богино тоглолт тоглох. Дүрсэнд хүрсэн бол нүүх зэрэг энгийн тохиролцсон дэгийг мөрдөх.
1.6 Монгол шатрын дүрсний уламжлалт нэршлийг таньж, өрсөлдөгчөө хүндэтгэн шударга тоглоно.	Монгол шатрын дүрсний нэр, дүрслэлийг олон улсын шатартай харьцуулах. Тоглолтын өмнө болон дараа мэндлэх, талархах үйлдлийг хэвшүүлэх. Маргаантай үед багшаас тусламж хүсэж, тайван ярилцах дүрд тоглох.

ХОЁРДУГААР АНГИ: СУУРЬ ТАКТИК БА БҮТЭН ӨРӨГ

Суралцахуйн үр дүн	Жишиг суралцахуйн үйл ажиллагаа
2.1 Сэлгээ, зөрөхдөө идэх зэрэг тусгай нүүдлийг таньж, зөв нөхцөлд хэрэглэнэ.	Богино, урт сэлгээ хийх боломжтой ба боломжгүй байрлалыг ялгах. Зөрөхдөө идэх нүүдлийг хөлөг дээр дарааллаар хийж үзүүлэх. Тусгай нүүдэл орсон богино даалгавар гүйцэтгэх.
2.2 Дүрсийн болон нүдний тэмдэглэгээг таньж, цөөн нүүдлийг энгийн бичлэгээр тэмдэглэнэ.	Монгол нэршил болон K, Q, R, B, N тэмдэглэгээг харьцуулж таних. Багшийн үзүүлсэн 3–5 нүүдлийг нүдний тэмдэглэгээтэй бичих. Энгийн бичлэгийг уншин хөлөг дээр нүүдэл хийх.
2.3 Давхар цохилт, нээж шалах, дараас аргуудыг хялбар байрлалд хэрэглэнэ.	Мориор хоёр дүрсэд зэрэг довтлох сэрээний бодлого бодох. Тэрэг, тэмээ, бэрсээр шорлох байрлалыг таних. Даруулсан дүрсийг олж, яагаад нүүхэд хүндрэлтэйг тайлбарлах.
2.4 Нээлтийн төв эзлэх, дүрс хөгжүүлэх, ноёноо хамгаалах зарчмыг дагаж тоглоно.	Өргийг төвийн хүүгээр эхэлж, хөнгөн дүрсээ хөгжүүлэх. Нэг дүрсээр шаардлагагүй олон удаа нүүхийн сул талыг жишээгээр харах. Эхний 6–8 нүүдэлд нээлтийн зарчмыг хэр дагаснаа шалгах.

2.5 Ноён, бэрс болон ноён, тэргээр энгийн мад хийж, ноён-хүүгийн төгсгөлийг тоглоно.	Ноёны тусламжтай бэрсээр мэдлэх дарааллыг дагаж хийх. Ноён, тэргээр эсрэг ноёныг зах руу шахах дасгал хийх. Ноёноор хүүгээ дэмжин сүүлчийн шугамд хүргэх.
2.6 Бүтэн өрөг тоглож, үр дүнгээ ярилцахдаа шатрын ёс зүйг баримтална.	Энгийн бүтэн өрөг тоглож, хожил, хожигдол, тэнцээг зөв бүртгэх. Тоглолтын дараа нэг сайн, нэг сайжруулах нүүдлээ нэрлэх. Монголын шатарчдын амжилтын тухай товч мэдээлэл сонсож ярилцах.

ГУРАВДУГААР АНГИ: СУУРЬ ТАКТИКИЙН ХЭРЭГЛЭЭ БА ӨӨРИЙН ТОГЛОЛТ

Суралцахуйн үр дүн	Жишиг суралцахуйн үйл ажиллагаа
3.1 Шатрын түгээмэл тэмдэглэгээг ашиглан өргийн гол нүүдлийг тэмдэглэж, хялбар бичлэгийг уншина.	Идэх, шаг, мад, сэлгээний тэмдэглэгээг жишээгээр тайлбарлах Тоглолтын эхний 8–10 нүүдлийг тэмдэглэх. Богино бичлэгийг уншин хөлөг дээр сэргээн тоглох.
3.2 Давхар цохилт, нээж шалах, дараас аргуудыг энгийн байрлалд сонгон хэрэглэнэ.	Аль тактик тохирохыг сонгох зурагт бодлого бодох. Нэг нүүдлээр материал хожих боломжийг олох. Хосоороо тактикийн байрлал зохиож, шийдлийг тайлбарлах.
3.3 Дүрсийн хүч, хамгаалалт, идэвх болон ноёны аюулгүй байдлыг харьцуулж, энгийн байрлалыг үнэлнэ.	Хоёр байрлалаас аль дүрс илүү идэвхтэйг сонгож тайлбарлах. Хамгаалагдсан ба хамгаалалтгүй дүрсийг хөлөг дээр олох. Ноёны аюулгүй байдлыг шалгах гурван асуултаар байрлал үнэлэх.
3.4 Ноён, хүүгийн энгийн төгсгөлд ноёноо идэвхтэй ашиглан хүүгээ ахиулна.	Ноёноор хүүгээ хамгаалж урагшлуулах дасгал хийх. Хүүг зогсоохдоо ноёноо зөв ойртуулах. Хожих эсвэл тэнцэх хялбар байрлалыг ялгах.
3.5 Өөрийн тоглолтыг эргэн харж, зөв болон алдаатай нүүдлээ тодорхойлно.	Тоглолтын гол 5–10 нүүдлийг хөлөг дээр дахин тоглох. Дүрс алдсан эсвэл боломж ашиглаагүй нэг нүүдлийг олох. Дараагийн тоглолтод сайжруулах нэг зорилго бичих.
3.6 Монгол шатрын тоглох ёс, дохио, уламжлалт нэр томъёог таньж, соёлтой хэрэглэнэ.	Шаг, шүүг, мүү зэрэг дохионы утгыг багшийн тайлбараар таних. Монгол ахуйтай холбоотой шатрын бодлого, даалгавар гүйцэтгэх. Монгол болон олон улсын шатрын нэг ижил, нэг ялгаатай талыг нэрлэх.

ДӨРӨВДҮГЭЭР АНГИ: ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ТОГЛОЛТ БА ЭНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Суралцахуйн үр дүн	Жишиг суралцахуйн үйл ажиллагаа
4.1 Шатрын цаг болон тэмцээний энгийн дүрмийг зөв хэрэглэн тоглоно.	Шатрын цагийг нүүдэл бүрийн дараа зөв дарах дадлага хийх. Тэнцээ санал болгох, буруу нүүдэл гарвал багшид мэдэгдэх дэгийг давтах. Ангийн нөхөрсөг тоглолтод цаг, ээлж, үр дүнгийн дэг мөрдөх.

4.2 Нэг, хоёр нүүдлийн тактикийн боломжийг олж, тохирох аргыг хэрэглэнэ.	Нэг, хоёр нүүдлийн , Давхар цохилт, нээж шалах, дараас аргуудын бодлого бодох. Хамгаалалтгүй дүрс болон шууд аюулыг нүүдэл хийхийн өмнө шалгах. Тактикийн шийдлээ нүүдлийн дарааллаар амаар тайлбарлах.
4.3 Дүрсийн хүч, хамгаалалт, идэвхийг харьцуулж, тоглолтын энгийн төлөвлөгөө гаргана.	Сул болон сайн байрласан дүрсийг олж, сайжруулах нүүдэл санал болгох. Нээлттэй шугамд тэргээ байрлуулах дасгал хийх. Дараагийн 1–2 зорилгоо тодорхойлон тоглох.
4.4 Хүү болон тэрэг оролцсон хялбар төгсгөлийн байрлалыг тоглоно.	Ноён, хүүгээр бэрс гаргах хялбар байрлал тоглох. Тэргээр эсрэг хүүг араас нь хянах дасгал хийх. Давуу хүүгээ хамгаалан ахиулах богино тоглолт хийх.
4.5 Тоглолтын үед цагаа хуваарилж, анхаарал болон сэтгэл хөдлөлөө зохицуулна.	Нүүдэл хийхийн өмнө “аюул–боломж–сонголт” дарааллаар шалгах. Хугацаатай бодлого, богино тоглолтоор цагаа хуваарилах. Хожигдсон үед тайван байж, өрсөлдөгчдөө баяр хүргэх дадал хэвшүүлэх.
4.6 Өөрийн сургууль, орон нутгийн шатрын уламжлалын талаар мэдээлэл цуглуулж танилцуулна.	Ахмад шатарчин, багш эсвэл шатрын тамирчинтай ярилцлага хийх. Орон нутгийн шатрын нэг үйл явдал, хүний тухай зурагт мэдээлэл бэлтгэх. Цуглуулсан мэдээллээ ангидаа товч танилцуулах.

ТАВДУГААР АНГИ: БИЕ ДААСАН ТОГЛОЛТ БА ШАТРЫН ӨВ

Суралцахуйн үр дүн	Жишиг суралцахуйн үйл ажиллагаа
5.1 Шатрын дүрэм, тэмцээний дэгийг бие даан мөрдөж, нөхөрсөг тоглолтод хариуцлагатай оролцоно.	Ангийн нөхөрсөг тоглолтын хослол, үр дүнг багшийн дэмжлэгтэй бүртгэх, хуваарь гаргах. Маргаантай үед цагаа зогсоож, багшид тайван тайлбарлах. Тоглолтын орчин, хөлөг, дүрсээ эмх цэгцтэй ашиглах.
5.2 Сурсан тактикийн аргуудаас тохирохыг сонгон, нэгээс хоёр нүүдлийн шийдэл олно.	Давхар цохилт, нээж шалах, дараас аргуудыг, нээж довтлохыг ялган бодлого бодох. Боломжит хоёр нүүдлийг харьцуулж, аюулгүйг сонгох. Шийдлийнхээ зорилгыг товч тайлбарлах.
5.3 Байрлалыг материал, дүрсийн идэвх, ноёны аюулгүй байдлаар үнэлж, энгийн төлөвлөгөө гаргана.	Материалын тоог харьцуулж, аль тал давуутайг тогтоох. Идэвхгүй нэг дүрсээ сайжруулах нүүдэл санал болгох. Өргийн тухайн үед хэрэгжүүлэх 1–2 зорилго тодорхойлох.
5.4 Сурсан мэд болон хүүгийн төгсгөлийн аргыг тоглолтод зөв хэрэглэнэ.	Ноён, бэрс болон ноён, тэргээр мэдлэхыг давтан бататгах. Ноён, хүүгийн хялбар төгсгөлийг хоёр талаас нь тоглох. Дүрс солилцсоны дараах төгсгөлийг өөрт ашигтай эсэхээр ярилцах.
5.5 Өөрийн тоглолтыг тэмдэглэлд тулгуурлан эргэн харж, сайжруулах арга замаа тодорхойлно.	Өөрийн нэг өргийн гол нүүдлийг хөлөг дээр сэргээн тоглох. Нэг сайн шийдвэр, нэг алдаа, нэг сайжруулах аргаа тэмдэглэх, ярилцах. Хосоороо тоглолтоо ярилцаж, соёлтой , ёс зүйтэйгээр санал солилцох, мэтгэлцэх.

5.6 Монгол шатрын өв, уламжлалыг бусдад танилцуулах, бүтээлч үйл ажиллагаанд оролцоно.	Монгол шатрын нэршил, тоглох ёсны тухай постер эсвэл жижиг ном бүтээх. Бага ангийн сурагчдад нэг дүрэм, бодлогыг жишээгээр тайлбарлах. Ангиараа шатрын өвийн үзэсгэлэн эсвэл өдөрлөг зохион байгуулах.
--	--

5.3. АРГА ЗҮЙ

Бага ангийн сурагчдын нас, сэтгэхүй, танин мэдэхүйн онцлог, сурах идэвхэд нийцүүлэн дараах арга зүйг хослуулан хэрэглэнэ.

- Тоглоомд суурилсан арга зүй: Шатрын дүрс, нүүдэл, дүрмийг үлгэрчилсэн түүх, дүрд тоглох, буухиа болон туслах тоглоомоор дамжуулан ойлгуулж, дадлагажуулна.
- Асуудал шийдвэрлэх арга зүй: Тодорхой байрлал, бодлого өгч, “Ямар нүүдэл хийх вэ?”, “Яагаад?”, “Өөр ямар хувилбар байна вэ?” зэрэг асуултаар бие даан болон хосоор ажиллуулж, мэтгэлцүүлэх ба энэ нь баримт нотолгоонд тулгуурланшийдвэр гаргах, шүүн тунгаах чадварыг хөгжүүлнэ.
- Хамтран суралцах арга зүй: Сурагчдыг хос, багаараа тоглох, бодлогын талаар хэлэлцэх, нүүдлээ тайлбарлах, тоглолтоо эргэн шинжлэх, харилцан санал солилцох зэрэг үйл ажиллагаанд оролцуулна. Хосолсон сургалтын арга зүй: Хөлөг, дүрс, карт зэрэг бодит хэрэглэгдэхүүнийг ухаалаг самбар, таблет, шатрын сургалтын аппликейшн, цахим платформтой зохистой хослуулан интерактив дасгал, бодлого, тоглолтод ашиглана. Дижитал хэрэглэгдэхүүнийг сурагчдын аюулгүй байдал, боломжид нийцүүлэн багшийн удирдлага дор зохион байгуулна

Ялгаатай хэрэгцээг дэмжих

Сурагчдын хөгжлийн онцлог, өмнөх мэдлэг, суралцах хурд, сонирхол, хэрэгцээнд нийцүүлэн сургалтын хэрэглэгдэхүүн, даалгавар, дэмжлэг болон үр дүнгээ илэрхийлэх хэлбэрийг уян хатан зохицуулна. Тухайлбал,

- Суралцахуйн үр дүнг дүрс нүүлгэх, зураг зурах, амаар тайлбарлах, тэмдэглэл бичих зэрэг олон хэлбэрээр илэрхийлэх боломж олгоно.
- Бодлого, даалгаврыг нэг алхамт, хоёр алхамт, нээлттэй сорил гэсэн түвшнээр ялган санал болгоно.
- Харааны бэрхшээлтэй сурагчид тэмтрэгдэх хөлөг, том дүрс, аман координат; хөдөлгөөний бэрхшээлтэй сурагчид хамтрагчийн дэмжлэгтэйгээр нүүдэл гүйцэтгэх, дижитал хөлөг ашиглах боломж бүрдүүлнэ.
- Анхаарал төвлөрүүлэхэд дэмжлэг шаардлагатай сурагчид богино, тодорхой даалгавар, харагдах таймер, тогтсон “зогс–хар–бод–нүү” дохио хэрэглэнэ.
- Шатрын мэдлэг, туршлагатай сурагчид нэмэлт бодлого өгөхөөс гадна шийдлээ тайлбарлах, бодлого зохиох, хувилбарыг харьцуулах, бусдад дэмжлэг үзүүлэх зэрэг ахисан түвшний үүрэг гүйцэтгүүлнэ.

5.4. СУРГАЛТЫН ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Орчин

Материаллаг орчин: Хүүхдийн биеийн өсөлтөд тохирсон ширээ, сандал бүхий зориулалтын шатрын анги эсвэл танхим байна. Нэг ширээнд хоёр сурагч сууж тоглох боломжтой байх, хөдөлгөөн, хараа, сонсгол, хэл-ярианы ялгаатай сурагчийн хэрэгцээнд тохируулсан хэрэглэгдэхүүн байх

Сэтгэл зүйн орчин: Алдаа гаргахаас айхгүй байх, хожих эсвэл хожигдохыг эрүүл ухаанаар хүлээн авч, бие биеэ хүндэтгэх эерэг дулаан уур амьсгалыг бүрдүүлэх.

Хэрэглэгдэхүүн

- Хоёр суралцагч тутамд нэг стандарт шатрын хөлөг ба дүрсний иж бүрдэл (соронзон хөлөг илүү тохиромжтой).
- Багш анги нийтэд үзүүлэн заах соронзонтой том хэмжээний шатрын самбар.
- Цахим ухаалаг самбар, проектор.
- Шатрын дижитал цаг (цахим бус орчинд ашиглах элсэн цаг, харагдахуйц хугацаа хэмжигч таймер).
- Шатрын орон зайн баримжаа (координат), дүрсний нүүдэл, тактикийн хэв шинжийг харуулсан үзүүлэнгийн картууд.
- Сурагчийн дасгал ажлын дэвтэр, түвшин ялгасан шатрын бодлогын хураамж ба ажлын хуудаснууд.
- Сурагч тус бүрийн ахиц дэвшлийг цуглуулах бүтээлийн хавтас.
- Монгол шатрын уламжлалт хийц, соёлын жишээ, гэрэл зураг болон орон нутгийн түүхэн тэмдэглэл, материалууд.

ЗУРГАА. ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТ

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

“Их нүүдэл” шатрын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- сурагчийн хөгжлийн онцлогт нийцсэн байх,
- оролцох боломжийг тэгш хангасан байх,
- суралцахуйн үр дүнг залгамж холбоотой хөгжүүлэх,
- сургуулийн нөхцөл, нөөц боломжид нийцүүлэн уян хатан зохион байгуулах,
- сурагчийн сонирхол, идэвхтэй оролцоог дэмжих,
- аюулгүй, хүндэтгэлтэй, шударга тоглолтын орчныг бүрдүүлэх,
- сургууль–гэр бүл–орон нутгийн байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлах

Хөтөлбөрийн хэрэгжилт нь зөвхөн шатар тоглох арга техникийг эзэмшүүлэхэд бус, сурагчийн шүүн тунгаах, асуудал шийдвэрлэх, төлөвлөх, шийдвэр гаргах, өөрийн сэтгэл хөдлөлөө удирдах, зохицуулах, өрсөлдөгчөө хүндэтгэх чадварыг дэмжихэд чиглэнэ. Монгол шатрын уламжлал, нэршил, тоглох ёс, олон улсын шатрын соёлыг сургалтын үйл ажиллагаа бүрд чухалчлан хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэлбэр

“Их нүүдэл” хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх нэмэлт хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Сургууль хичээлийн жилийн эхэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх анги, бүлэг, багш, сургалтын орчин, шаардлагатай хэрэглэгдэхүүнийг тодорхойлон жилийн нэгдсэн төлөвлөгөөндөө тусгана.

Хөтөлбөрийг тогтмол хуваарийн дагуу хэрэгжүүлэхийг үндсэн хэлбэр болгох бөгөөд сургуулийн арга хэмжээ, тэмцээн, амралтын хугацаатай уялдуулан зохистой өөрчлөх боломжтой.

6.3. Сургуулийн түвшний зохион байгуулалт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ сургалтыг дэмжих үйл ажиллагаа, хөгжүүлэх үйл ажиллагааны нэг хэсэг болгон төлөвлөж, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангана.

Сургууль дараах үндсэн зохион байгуулалтыг хариуцна:

- хөтөлбөрийг хэрэгжүүлэх анги, сурагчийн хамрах хүрээг тодорхойлох;
- сургалтын хуваарь батлах;
- хөтөлбөр хэрэгжүүлэх багшийг сонгон, бэлтгэх;
- шатрын хөлөг, дүрс, цаг, бодлого дасгалын материал болон бусад хэрэглэгдэхүүнээр хангах;
- сургалт явуулах тохиромжтой орчин бүрдүүлэх;
- сурагчийн оролцоо, ахиц, хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээллийг сурталчлах, мэдээлэх;
- сургуулийн дотоодын нөхөрсөг тоглолт, шатрын өдөрлөг, тэмцээн зохион байгуулах;
- орон нутгийн шатрын байгууллага болон бусад сургуультай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Сургуулийн удирдлага хөтөлбөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, багшийн ажлын зохион байгуулалт, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, мэргэжил арга зүйн дэмжлэгийг төлөвлөнө.

6.4. Багшийн зохион байгуулалт

Хөтөлбөрийн тогтвортой хэрэгжилтийг хангах зорилгоор нэг сургуульд хоёр багшийг “Их нүүдэл” хөтөлбөрөөр бэлтгэн ажиллуулна.

Хөтөлбөр хэрэгжүүлэх багшид мэргэжлийн шатарчин байх шаардлага тавихаас илүүтэй шатрын үндсэн дүрэм, агуулгыг эзэмшсэн, хөтөлбөрийн арга зүйн сургалтад хамрагдсан, бага насны сурагчтай ажиллах чадвартай байна. Багшийг хөтөлбөрийн агуулга, арга зүй, шатрын дүрэм, тэмцээн зохион байгуулах суурь мэдлэг, чадварыг хамарсан мэргэжил, арга зүйн бэлтгэлээр хангана.

6.5. Суралцагчийн оролцоо, бүлгийн зохион байгуулалт

Хөтөлбөрийн хамрах хүрээг сургуулийн хүчин чадал, багшийн нөөц, сурагчийн сонирхол, эцэг эх, асран хамгаалагчийн мэдээлэлтэй уялдуулан тогтооно.

Шатар шинээр сурч байгаа болон тодорхой түвшний чадвартай сурагчдыг нэг ижил шалгуураар хэмжихгүй бөгөөд хөтөлбөр нь эхлэгч суралцагчаас шатлан ахих боломжтой байхаар зохион байгуулагдана. Ахисан түвшний сурагчдад нэмэлт бодлого, тоглолт, тэмцээнд оролцох боломжийг сургууль, бүрдүүлж болно.

6.6. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагчид хосоор болон баг, бүлгээр тоглох боломжтой, тайван, аюулгүй сургалтын орчин бүрдүүлнэ. Сургалтын үндсэн хэрэглэгдэхүүнд шатрын хөлөг, дүрс, үзүүлэнгийн хөлөг, бодлого, дасгалын материал, тэмдэглэгээний хэрэгсэл багтана. Ахисан түвшний сургалт, тэмцээнд шатрын цаг болон шаардлагатай бусад хэрэглэгдэхүүнийг ашиглаж болно.

Сургалтын хэрэглэгдэхүүнийг анги бүрийн агуулга, сурагчийн ур чадварын түвшинд тохируулан сонгоно. Сургууль боломжтой тохиолдолд цахим бодлого, интерактив сургалтын хэрэглэгдэхүүн болон шатрын сургалтын дижитал эх үүсвэрийг нэмэлтээр ашиглаж болно.

6.7. Орон нутгийн хамтын ажиллагаа

Сургууль нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ аймаг, нийслэл, дүүрэг, орон нутгийн шатрын холбоо, шатрын клуб, дасгалжуулагч болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. .

Хамтын ажиллагаа нь:

- багшид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- багшийн сургалт, дадлага зохион байгуулах;
- сурагчдад зориулсан нөхөрсөг тоглолт, өдөрлөг зохион байгуулах;
- сургууль хоорондын тэмцээн зохион байгуулах;
- шатрын ур чадвар өндөр сурагчийг дараагийн шатны сургалт, клубтэй холбох;
- шатрын соёл, уламжлалыг сурталчлах;
- шатрын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлэх.

Орон нутгийн шатрын холбоотой хамтран ажиллах нь сургуулийн шатрын сургалтыг мэргэжлийн шатрын спорттой заавал нэгтгэх бус, харин хөтөлбөрийн чанар, багшийн мэргэжлийн хөгжил, сурагчийн цаашид хөгжих боломжийг дэмжихэд чиглэнэ.

6.8. Сургуулиудын хамтын ажиллагаа

“Их нүүдэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуулиудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох, хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор Монголын сургуулиудын шатрын холбоо байгуулах чиглэл баримтална.

Тус холбооны үйл ажиллагааг дараах үндсэн чиглэлээр хөгжүүлж болно.Үүнд:

- “Их нүүдэл” шатрын хөтөлбөр хэрэгжүүлж буй сургуулиудыг сүлжээнд холбох;
- багш нарын мэргэжлийн хамтын нийгэмлэгийг дэмжих;
- сургалтын туршлага, хэрэглэгдэхүүн, сайн туршлагыг түгээх;
- сургуулийн, орон нутгийн болон үндэсний хэмжээний шатрын үйл ажиллагаануудыг уялдуулах;
- сурагчдын нөхөрсөг тоглолт, тэмцээнийг нэмэгдүүлэх;
- багш, сурагчийн хөгжлийг дэмжих сургалт, уулзалт, арга хэмжээ зохион байгуулах;
- Монгол шатрын өв соёл, тоглох уламжлалыг хүүхэд, залуу үед түгээн дэлгэрүүлэх;

Ингэснээр сургуулийн шатрын үйл ажиллагаа тус тусдаа зохион байгуулагдахаас илүүтэй сургуулиуд харилцан суралцах, хамтран ажиллах, сурагчид сургуулиас сургууль, орон нутгаас үндэсний түвшинд туршлага солилцох боломжтой сүлжээ бий болно.

6.9. Тэмцээн, хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт

Тэмцээн нь хөтөлбөрийн үндсэн зорилго бус, сурагч эзэмшсэн мэдлэг, чадвараа хэрэглэх, бусадтай тоглох, тоглох соёлд суралцах, туршлага хуримтлуулах талбар нь байна. Тэмцээний үр дүнг зөвхөн хожил, байр эзлэлтээр үнэлэхгүй бөгөөд шударга тоглолт, дүрэм мөрдөх, өрсөлдөгчөө хүндэтгэх, тоглолтоо дуусгах, үр дүнгээ хүлээн зөвшөөрөхөд чиглүүлнэ..

Сургуулийн түвшинд нөхөрсөг тоглолт, анги болон насны бүлгийн тэмцээн зохион байгуулж, цаашид сургууль хоорондын, орон нутгийн болон үндэсний түвшний арга хэмжээнд үе шаттай оролцох боломжийг бүрдүүлж болно.

6.1.0 Дэмжлэг, хяналт

Хөтөлбөрийн хэрэгжилтэд суралцагчдыг хамрагдалт, оролцоо, агуулгын хэрэгжилт, багшийн бэлтгэл, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмж, анги хоорондын залгамж холбоог хамтатган авч үзнэ.

Сургууль нь хичээлийн жилийн төгсгөлд хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, дараагийн жилийн зохион байгуулалтад шаардлагатай өөрчлөлтийг тусгана. Орон нутгийн болон сургуулиудын шатрын хамтын ажиллагааны байгууллага нь хэрэгжилтийн сайн туршлагыг нэгтгэх, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын чанарыг сайжруулахад чиглэн ажиллана.

Хүснэгт 2. Шатрын сургалтын цагийн жишиг төлөвлөлт

Анги	14 хоногт	Хичээлийн жилд
1-р анги	1	16
2-р анги	1	16
3-р анги	1	16
4-р анги	1	16
5-р анги	1	16
НИЙТ		80

Сургалтыг 30-40 минутаар төлөвлөж болох бөгөөд сургуулийн баталсан хуваарьт нийцүүлэн 30-40 минутын блок, клубийн 60-80 минутын хос цаг, эсвэл улирлын эрчимжүүлсэн хэлбэрээр зохион байгуулж болно. Аль ч тохиолдолд анги тус бүрийн жилийн суралцахуйн үр дүн, нийт 16 цагийг хангасан байна.


Сургууль, анги удирдсан багш нь сургалтын үр дүнг сайжруулах, суралцагчид бие даан болон хамтран ажиллаж, сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвараа бататгах зорилгоор завсарлага, чөлөөт цагаар шатар тоглох орчныг бүрдүүлж, дэмжлэг үзүүлнэ.

Сэтгэл ханамжийн судалгаа зохион байгуулах

Шатрын хөтөлбөрийн хэрэгжилтийг сэтгэл ханамжийн судалгаагаар хянах боломжтой. Сэтгэл ханамжийн судалгааг сургалтын агуулга, хэлбэр нь уян хатан, багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдад ойлгомжтой эсэх, нээлттэй, ил тод байгаа эсэх; сул байгааг төлөвлөх дэмжих, үйл ажиллагааны төлөвлөгөөг сайжруулах, харилцаа, хандлага, уур амьсгал, үйл ажиллагаанд сэтгэл ханамж хэр байгаа талаар тодорхойлж, үнэлэлт дүгнэлт хийж, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашид сайжруулах зорилготой хийнэ.

Сэтгэл ханамж нь багшийн санал болгож буй хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаа нь сурагчийн хүлээлтэд хэрхэн нийцэж байна вэ гэдгийг тодорхойлдог өргөн ойлголт юм. Сэтгэл ханамж нь тодорхой хэмжүүрийн дагуу тооцогддог ба сургалт үйл ажиллагаагаа хөгжүүлэх шат дамжлагыг нарийн тодорхойлж өгдгөөрөө давуу талтай. Сэтгэл ханамжийн судалгаа нь шатрын хөтөлбөрт гарч буй өөрчлөлт чанар, сайжруулах эсэх талаарх санал бодлыг багш, суралцагч, эцэг эх хэрхэн үнэлж байгааг илтгэнэ.

Сэтгэл ханамжийн судалгааны арга аргачлал



“Сэтгэл ханамжийн асуулга” нь (тодорхой асуулгын тоо хэд ч байж болно) асуулгаар Ликертийн 1- 5 гэсэн оноогоор үнэлэгдэх бөгөөд “1” нь сэтгэлд огт нийцэхгүй, “2” сэтгэлд нийцэхгүй, “3” дунд зэрэг нийцнэ, “4” сэтгэлд нийцнэ, “5” хамгийн их сэтгэлд нийцэж байна гэсэн хувилбартай байж болно.

Шатрын хөтөлбөрийн үр дүнг сайжруулах, үйл ажиллагааг төлөвлөх, агуулгыг тодруулах зорилгоор бид сурагчид, эцэг эх багш нараас сэтгэл ханамжийн судалгаагаар дүгнэлт хийж судалгааны үр дүнг тооцоолох боломжтой юм.

Сэтгэл ханамжийн судалгааг эцэг, эх асран хамгаалагчид - сурагчид (бага анги, дунд анги, ахлах анги), багш нараас авч болох ба энэ үйл ажиллагаанд хамрагдаж байгаа бусад хүмүүсээс авч болох юм. Сэтгэл ханамжийн судалгааг дараах зорилгоор хэрэглэнэ. Үүнд:

- Шатрын хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлыг илрүүлэх
- Хөтөлбөрийн явцад сурагчдын болон эцэг эхийн сэтгэл ханамжийг илрүүлэх
- Шатрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гарч буй өөрчлөлтүүдийг тодруулах, сайжруулах харьцуулах
- Хөтөлбөрт хамрагдаж буй сурагчдын ялгаатай хэрэгцээг хангаж байгааг тодруулах, тэгш бус байдал байгаа эсэхийг шалгах, илрүүлэх

Судалгааны бүхий л шатанд гарсан процесс, санал дүгнэлт, шийдвэр, асуулгын сан үүсгэх зэргийг тусгасан байна. Мөн энэхүү судалгааны гарсан үр дүнг нийтэд ойлгомжтой хэлбэрээр харуулах.

Жишээ 1: Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа

Уг судалгааны үр дүнд тулгуурлан бид үйл ажиллагаандаа шинжилгээ хийж, өөрчлөлт, шинэчлэлт хийн ажиллах тул та бүхэн дараах асуултуудад үнэн зөвөөр хариулна уу?

1. Таны хүүхэд шатрын хөтөлбөрт өөрийн саналаар хамрагдаж байгаа юу?
а. 1/ Тийм өөрөө сонгож 2/ Үгүй миний зөвлөснөөр
2. Таны хүүхдэд ямар өөрчлөлт ороосой гэж Та үзэж байна вэ?
а. Бие дааж суралцах чадвартай болох б. Бүтээлч сэтгэлгээтэй болгох в. Ямар нэг зүйлийг тууштай хийдэг болгох г. Нийтэч болгох д. Бусад
3. Таны хүүхдийн сонирхлыг хүндэтгэн сонирхсон зүйлийг нь заана гэж Та итгэж байна уу?
а. Тийм б. Үгүй
4. Та хүүхдийнхээ суралцдаг энэ сургалтын үйл ажиллагааг үнэлнэ үү?
а. Маш сайн б. Хангалттай в. Дундаж г. Хангалтгүй д. Маш хангалтгүй
5. Таны бодлоор хүүхдийн тань сонирхол нэмэгдэж сайжирч байна уу
а. Маш их сайжирсан б. Сайжирсан в. Хэвийн урьдынх шигээ г. Сайжраагүй д. Бусад
6. Энэ үйл ажиллагаанд (сургалтад) хүүхдээ хамруулахад хүндрэл бэрхшээлүүд юу байна вэ?
а. Орж байгаа хэрэглэгдэхүүн үнэ ихтэй б. Ном гарын авлага ховор в. Маш их ачаалалтай г. Мэдэхгүй
7. Орж байгаа сургалтын талаар мэдээ, мэдээллийг ямар хэлбэрээр авбал илүү үр дүнтэй байх вэ?
а. Гарын авлага хэлбэрээр б. Цахим хуудсаар /Фейсбүүк, вэбсайт ... гэх мэт/ в. Эцэг эхэд зохион байгуулсан сургалтаар
8. Сургалт (үйл ажиллагаа) -г зохион байгуулж байгаа багшийн мэдлэг, ур чадварыг үнэлнэ үү?
а. Маш сайн б. Хангалттай в. Дундаж г. Хангалтгүй
9. Сургалт болон үйл ажиллагааны тайлагналттай холбоотой мэдээллийг ямар хэлбэрээр авбал илүү үр дүнтэй гэж Та үзэж байна вэ?
а. Цахимаар б. Танхимын тайлангаар

Жишээ 2 Суралцаж буй сурагчдаас авах сэтгэл ханамжийн судалгаа

1. Та энэ сургалтад (үйл ажиллагаанд) өөрийн саналаар хамрагдаж байгаа юу?
а/ Тийм - өөрөө сонгож б/ Үгүй - эцэг эхийн зөвлөснөөр
2. Энэхүү хөтөлбөрт хамрагдахад ямар хүндрэл бэрхшээл тохиолдож байна вэ?
а/ Орж байгаа хэрэглэгдэхүүн үнэ ихтэй б/ Ном гарын авлага ховор
в/ Маш их ачаалалтай г/ Мэдэхгүй
4. Та үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа хэрэглэгдэхүүнийг ямар хэлбэрээр авбал илүү үр дүнтэй байх вэ?
а/ Гарын авлага хэлбэрээр б/ Цахим хуудсаар /Фейсбүүк, вэбсайт ... гэх мэт/
в/ Эцэг эхэд зориулсан сургалтаар
5. Хөтөлбөрийг зохион байгуулж байгаа багшийн мэдлэг, ур чадварыг үнэлнэ үү?
а/ Маш сайн б/ Хангалттай
в/ Дундаж г/ Хангалтгүй

ДОЛОО. “ИХ НҮҮДЭЛ” ШАТРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Энэхүү зөвлөмж нь сурагчдын оролцоонд тулгуурлан нас сэтгэхүй, хөгжил төлөвшил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрхэн зохион байгуулж, чиглүүлж болох талаар санаа өгөх, ерөнхий чиглүүлэг удирдамж болгох зорилготой тул өөрийн орон нутаг, сургууль, сурагчдын нөхцөл байдал, хувь шинж, онцлог сонирхолтой нь уялдуулан бүтээлчээр ашиглана гэдэгт найдаж байна.

Шатрын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчдад өөрийгөө удирдан хөгжүүлэх, манлайлах, харилцах, сурах арга барилыг сайжруулах, тодорхой асуудлыг шийдвэрлэх, бүтээлчээр сэтгэх, нийгмийн олон талт харилцаанд оролцох, түүнд өөрийн байр сууриа илэрхийлэх, бие хүний чадварууд хөгжих боломжтой болно.

Шатрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж нь дараах 2 үндсэн хэсэгтэй.

- Сурагчдын бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн ерөнхий онцлог
- Шатрын хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмж

6-17 НАСНЫ СУРАГЧДЫН ТАНИН МЭДЭХҮЙ, НИЙГЭМШЛИЙН ХӨГЖЛИЙН ОНЦЛОГ.

2014-2017 онд Боловсролын хүрээлэнгээс Монголын 6-17 насны хүүхдүүдийн танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдарын хөгжлийн онцлогийг цогц байдлаар судлан тогтоож түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг авч үзжээ. Судалгааны үр дүнг 6-17 нас тус бүрээр, бага боловсрол, суурь боловсрол, бүрэн дунд боловсролын түвшин тус бүрээр дундаж үзүүлэлтүүдийг гарсан.

6-17 насны хүүхдүүдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн ерөнхий онцлог

Бие бялдар	Танин мэдэхүй	Нийгэмшил
10-12 насанд охидын биеийн өндрийн үзүүлэлт, 14 наснаас эхлэн хөвгүүдийн биеийн өндрийн үзүүлэлт нэмэгддэг.	Мэдээллийг хүртэхдээ ерөнхийд нь хүртэх хандлагатай.	Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх нь эерэг болдог.
Охидын биеийн өндөр 14 наснаас, хөвгүүдийн биеийн өндрийн үзүүлэлт 16 наснаас удааширсан байна.	Юмсыг гадаад байдлаар нь харьцуулах чадвартай, дотоод мөн чанар, учир шалтгаанд нь харьцуулах нь сул байна.	Нийцтэй, нөхөрсөг, бусадтай харилцах, хамтрах сонирхол сайтай болно.
Охидын биеийн жин 11-14 насанд, хөвгүүдийн биеийн жин 13-15 насанд нэмэгдсэн.	Нарийн мэдээлэл агуулсан байнга хэрэглэдэггүй үг хэллэгтэй мэдээллийг утгачлан тогтоох нь сул байна.	Өсвөр насанд бусдыг хүлээн зөвшөөрөх нь буурч, шүүмжлэлтэй хандлага бий болно.
12 наснаас эхлэн суурь боловсролын түвшинд хүүхдүүдийн хурдны чанар саарсан 15-17 насанд хөвгүүдийн	Өдөр тутам байнга хэрэглэдэг, бодит юмсыг заасан үгийн нөөц давамгайлдаг. Тэмдэг нэр, салаа утгатай үгийн нөөц сул болсон байна.	Өсвөр насанд эцэг эхтэйгээ дотно харилцах нь суларсан.

хурд нэмэгдсэн. Нийт насанд хөвгүүдийн хурд илүү байна.		
Хөвгүүдийн хүчний чанар анги ахих тусам нэмэгдсэн.	Энгийн богино өгүүлбэрээр ярьдаг. “бөгөөд, гэвч, учраас, боловч, миний бодлоор” гэх мэт холбоос хэрэглэсэн нийлмэл өгүүлбэрийг нийт хүүхдүүд хэрэглэх нь маш бага байна.	Өсвөр насанд айдас нэмэгдсэн.

Бага боловсролын түвшинд суралцагчдын танин мэдэхүй, нийгэмшлийн онцлог:

Ажигч чанар

Юмс үзэгдлийн шинж чанар, гадаад байдлыг богино хугацаанд үнэн зөв ажиглах нь хангалтгүй байгаа ч 7 наснаас аажмаар нэмэгдэж 10 насанд хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь нас ахих тусам ажигч чанар сайжирч байна гэж дүгнэж болох юм. Анхаарлын чанарууд бага боловсролын түвшинд сул байна.

Сэтгэхүй:

7 наснаас эхлэн ухагдахууны талаарх ойлголтын төлөвшил нэмэгдэж байгаа ба 8-10 настай сурагчдын сэтгэхүйн задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, үйлдлийг юмсын гол шинжийг олох, сэтгэхүйн харьцуулах үйлдэл нь дундаж буюу дунджаас доогуур түвшинд байгаа нь эдгээр үйлдлүүд сул хөгжилтэй байгааг харуулж байна.

Хэл яриа:

- Бага ангид хүүхдүүдэд бодит үгийн нөөц давамгайлж байна.
- Бага ангийнхан энгийн богино өгүүлбэрээр санаагаа илэрхийлж, харагдаж байгаагаар нь юмыг тоочиж ярьдаг.
- Хүүхдүүд 9 наснаас эхлэн нийлмэл өгүүлбэрээр санаагаа илэрхийлж, дүгнэж ярьж эхэлдэг байна.

Нийгэмшлийн онцлогийгсэтгэлийн хөдөлгөөн, өөрийн ухамсар, дасан зохицол, ээнэгшилт, үнэт зүйл гэсэн үзүүлэлтүүдээр авч үзсэн.

- 8-10 насны сурагчдын хувьд өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар дундаж түвшинд байна.
- 8-10 настай сурагчдын 52 хувь нь өөртөө итгэлтэй байсан бол 10 наснаас өөртөө итгэх итгэл буурсан байна.
- 10 наснаас өөрийгөө таних ойлгох өөрийн хүндлэл буурч байгаа нь сурагчид өөрийнхөө юу хүсэж байгааг ойлгож өөрийгөө удирдаж эхэлдэг байна.
- Эцэг эх, асран хамгаалагчдадаа дотно, *ээнэгшин хандах* хандлага сайн байна.
- 6-10 насанд бусадтай нээлттэй идэвхтэй харилцах дуртай, илэн далангүй харилцаатай байна.

ШАТРЫН ХӨЛӨГ, ДҮРС, НҮҮДЭЛ, ТЭМДЭГЛЭГЭЭ, ӨРӨГ ТОГЛОХ БОЛОН ТЭМЦЭЭНИЙ ҮНДСЭН ДҮРМИЙГ ЭЗЭМШҮҮЛЭХ

1.1.2. Үндсэн ойлголт:

Шатрын хөлөг:

Хөлгийн бүтэц: 8*8 харьцаатай, нийт 64 нүднээс (32 цагаан, 32 хар) бүрддэг.

- Хөлгийн байрлал: Тоглоом эхлэхийн өмнө хөлгийн баруун доод өнцгийн нүд заавал цагаан өнгөтэй байна.
- Шугамууд:
 - Босоо шугам (Files): Латин a, b, c, d, e, f, g, h үсгээр тэмдэглэгдэнэ.
 - Хэвтээ шугам (Ranks): $1, 2, 3, 4, 5, 6, 7, 8$ тоогоор тэмдэглэгдэнэ.
 - Диагональ буюу ташуу шугам (Diagonals): Ижил өнгийн нүднүүдээр үргэлжлэх ташуу шугам.

Шатрын дүрсүүд ба тэдгээрийн нүүдэл:

Талууд тус бүр 16 дүрсээр (1 Ноён, 1 бэрс, 2 тэрэг, 2 тэмээ, 2 морь, 8 хүү) эхэлнэ.

- Ноён (King /K): Зэргэлдээх аль ч чиглэлд 1 нүд нүүнэ. Хамгийн чухал дүрс бөгөөд идэгдэхгүй, харин мэдлүүлдэг.
- Бэрс (Queen /Q): Хэвтээ, босоо, ташуу аль ч чиглэлд чөлөөтэй (саадгүй бол) хэдэн ч нүд нүүнэ. Хамгийн хүчтэй дүрс.
- Тэрэг (Rook /R): Зөвхөн хэвтээ болон босоо чиглэлд хэдэн ч нүд нүүнэ.
- Тэмээ (Bishop/B): Зөвхөн ташуу (диагональ) чиглэлд хэдэн ч нүд нүүнэ. Эхнээсээ хар ба цагаан нүдний тэмээ гэж ялгарна.
- Морь (Knight /N): "Г" үсгийн хэлбэрээр (2 нүд шулуун + 1 нүд хажуу тийш) нүүнэ. Өөр дүрсэн дээгүүр харайж чаддаг ганц дүрс.
- Хүү (Pawn): Урагшаа 1 нүд нүүнэ (анхны байрлалаас 2 нүд нүүх боломжтой). Идэхдээ урд талын хоёр ташуу нүдний аль нэгэнд байгаа дүрсийг иднэ.

Шатрын тусгай нүүдэл ба дүрэм

- Сэлгээ (Castling): Ноён ба Тэрэг нэгэн дор зэрэг нүүх тусгай нүүдэл.
 - *Богино сэлгээ* ($O-O$): Ноён талын тэрэгтэй нүүх.
 - *Урт сэлгээ* ($O-O-O$): Бэрс талын тэрэгтэй нүүх.
 - *Нөхцөл*: Ноён ба Тэрэг өмнө нь нүүгээгүй байх, дундаа дүрсгүй байх, Ноён шалуулаагүй ба шалгах нүдээр дайрч нүүхгүй байх.
- Замдаа идэх (En Passant): Эсрэг талын хүү анхны нүүдлээрээ 2 нүд урагшлан, таны хүүгийн хажууд ирэхэд, түүнийг урагш 1 нүд нүүсэн мэт замаас нь идэх тусгай дүрэм (зөвхөн дараагийн нүүдэл дээр л хэрэгжүүлнэ).
- Хүү бэрс гарах (Promotion): Хүү эсрэг талын хамгийн сүүлчийн буюу 8 дахь (эсвэл 1 дэх) хэвтээ шугамд хүрэхэд Ноёноос бусад аль ч хүчтэй дүрс (Бэрс, Тэрэг, Тэмээ, Морь) болж хувирна.

Шатрын тэмдэглэгээ .

- Дүрсүүдийн товчлол (Монгол / Англи):

- Ноён = $H(K)$, Бэрс = $B(Q)$, Тэрэг = $T(R)$, Тэмээ = $Tm(B)$, Морь = $M(N)$. Хүүд товчлол бичихгүй.
- Нүүдлийн тэмдэглэгээ:
 - Эхлээд дүрсийн товчлол, дараа нь очсон нүдний нэрийг бичнэ. (Ж: $Mf3$ – Морь $f3$ нүдэнд нүүв).
 - Идэх: : эсвэл х тэмдэгтээр тэмдэглэнэ. (Ж: $Vxd5$ эсвэл $Tm:d5$).
 - Шалах: + тэмдэгт.
 - Мадлах: # эсвэл х тэмдэгт.

Өрөг тоглох ба төгсгөлийн ойлголтууд

- Шалах (Check): Ноён руу шууд довтолсон байдал. Шалуулсан тал заавал Ноёноо аврах нүүдэл хийнэ (зугтах, хаалт хийх, довтолсон дүрсийг идэх).
- Мадлах (Checkmate): Ноён шалуулсан бөгөөд аврагдах ямар ч боломжгүй болсон байдал. Тоглоом шууд дуусаж, мадалсан тал хожно.
- Жид буюу Тэнцэх (Stalemate): Нүүх ажиллагаатай талын Ноён шалуулаагүй, гэхдээ дүрмийн дагуу нүүж болох ямар ч боломжит нүүдэлгүй болсон байдал. Өрөг тэнцээгээр дуусна
- Бусад тэнцээний тохиолдлууд:
 - Дараалан 3 удаа нэг байрлал давтагдах (3 -fold repetition).
 - 50 нүүдэл дотор ямар ч хүү нүүгээгүй, дүрс идэгдээгүй байх.
 - Мадлах хангалттай хүч үлдээгүй байх (жишээ нь: Ноён Ноёны эсрэг, Ноён+Тэмээ Ноёны эсрэг).

Тэмцээний үндсэн дүрмүүд ба ёс зүй

- "Барьсан бол нүүнэ" дүрэм (Touch-Move Rule)
 - Өөрийн дүрсэнд санаатайгаар хүрсэн бол заавал тухайн дүрсээр нүүнэ.
 - Эсрэг талын дүрсэнд хүрсэн бол боломжтой бол заавал тухайн дүрсийг эзэлж (иднэ).
 - Дүрсээ байрлуулах гэж засах бол өрсөлдөгчдөө заавал "Заслаа" (эсвэл "*I adjust*") гэж хэлсний дараа хүрнэ.
- Шатрын цаг барьж тоглох: Нүүдлээ хийж дуусаад заавал нүүдэл хийсэн гараараа цагаа шахах ёстой. Цаг дуусвал тухайн тал хожигдоно.
- Тэмцээний ёс зүй:
 - Өрөг эхлэхийн өмнө ба дууссаны дараа өрсөлдөгчтэйгөө гар барина.
 - Тоглолтын үеэр чимээ шуугиан гаргах, өрсөлдөгчийнхөө анхаарлыг сарниулахыг хориглоно.
 - Хожигдлоо хүлээн зөвшөөрөх ба ялалтад даруухан, хүндэтгэлтэй хандана.

1.1.3.Үйл ажиллагаа:

- Хөлгийн 64 нүд, босоо ($a-h$), хэвтээ ($1-8$) ба ташуу шугамуудыг тоглоомын аргаар заах.
- Багшийн дурдсан нүдийг (жишээ нь: $e4$, $c7$) хэн хурдан олж хуруугаараа заах тэмцээн явуулах.
- Дүрс бүрийн (ноён, бэрс, тэрэг, тэмээ, морь, хүү) нэр, онцлог, хүч болон байрлалыг танилцуулах.

- Суралцагчдад шатрын дүрсүүдийн маск/малгай өмсгөж, анхны байрлалдаа хэрхэн зөв жагсахыг бодит дээр баг болон өрүүлэх.
- Дүрс бүрийн нүүдлийг нэг нэгээр нь нүүх дасгалыг давтах.
- Хөлөг дээр саад (эсрэг талын дүрсүүд)-ууд тавьж, Морь болон тэмээгээр тухайн саадуудыг тойрч, харайж тодорхой нүдэнд хүрэх "Лабиринт" даалгавар биелүүлэх.
- Ноён ба тэрэгний хамтын ажиллагаа болох богино ба урт рокировка хийх нөхцөлийг үзүүлэн дээр тайлбарлах.
- Сэлгээ хийж болох ба болохгүй 5 өөр байрлал харуулж, суралцагчдаар зөв шийдлийг олуулах.
- "Хүүгийн уралдаан" мини-тоглоом (зөвхөн хүүнүүдээр тоглож, эсрэг талын сүүлчийн шугамд түрүүлж хүрч бэрс болох сорилт).
- Дүрсүүдийн товчлол (Н, Б, Т, Тм, М) болон нүдний хаягийг ашиглан нүүдлийг бичиж сургах.
- Багшийн хэлсэн 5 нүүдлийг шатрын дэвтэртээ зөв кодлон бичих, эсвэл кодлон бичсэн даалгаврыг хөлөг дээр нүүж харуулах.
- Хоёр суралцагч тоглож байхад нэг нь нүүдлээ бичиж, нөгөө нь хянах замаар өрөг тэмдэглэх дадалд суралцах.
- Ноён шалуулсан үед аврагдах 3 арга (1. Зугтах, 2. Хаалт хийх, 3. Довтолсон дүрсийг идэх)-ыг дадлагажуулах болон мэд болсон байрлалыг таних даалгаврууд ажиллуулах.
- Мэд ба Жид (нүүх нүүдэлгүй ч шалуулаагүй)-ын ялгаатай 1 нүүдлийн бодлогуудыг бодуулж, логик сэтгэлгээг нь хөгжүүлэх.
- Суралцагчдын дунд шатрын цаг ашиглан бичил тоглолт зохион байгуулах. Дүрсэнд хүрэхээсээ өмнө бодох, хүрсэн бол заавал нүүх дүрмийг бодит байдал дээр хэвшүүлэх.
- Өрөг эхлэхийн өмнө ба дууссаны дараа гараа барих, өрсөлдөгчид хүндэтгэлтэй хандаж "Сайн тоглолоо" гэж хэлэх, ялагдаж сурах зэрэг соёлтой харилцааны дадлуудыг жүжигчилсэн хэлбэрээр турших.
- Төгсгөлд нь сурсан бүх дүрэм, тэмдэглэгээ, цагийн хэрэглээгээ шалгах 3 раундын швейцар системтэй нөхөрсөг тэмцээн зохион байгуулах.

1.1.4 Арга зүй

Хамтран суралцах арга зүй

Суралцагчдыг хосоороо болон багаараа тоглох, бодлого шийдвэрлэх, нүүдлээ тайлбарлах, тоглолтоо эргэн шинжлэх, харилцан санал өгөх үйл ажиллагаанд оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.

Сурагчдын хийх үйл ажиллагаа

Алхам 1.Хосоороо ба багаараа тоглох

- "Зөвлөх ба тоглогч" хосын тоглоом: Хоёр сурагч нэг баг болж эсрэг багтайгаа тоглоно. Нэг нь нүүдэл хийх (тоглогч), нөгөө нь боломжит нүүдлийг ажиглаж, зөвлөгөө өгөх (зөвлөх) байдлаар үүргээ солилцон тоглоно.

- "Шатрын багийн буухиа" : Сурагчид 3–4 хүний бүрэлдэхүүнтэй баг болж, өөр багийн эсрэг тоглоно. Нүүдэл бүрийн өмнө багийн гишүүд хоорондоо богино хугацаанд зөвлөлдөн хамгийн оновчтой нүүдлийг сонгоно.

Алхам 2. Бодлого, асуудал шийдвэрлэх

- "Багийн мэд" бодлого бодох сорилт: Багаараа нэгдэн 1–3 нүүдлийн мэдлэх эсвэл тактикийн (сэрээ хийх, хавчаардах гэх мэт) бодлогуудыг хамтран шинжилж, хамгийн сайн шийдлийг олно.
- "Байрлалын оношилгоо" кейс ажил: Хөлөг дээрх тодорхой ээдрээтэй байрлалыг баг бүрт өгч, *"Хэн нь илүү боломжтой вэ?, Ямар төлөвлөгөө хэрэгжүүлэх вэ?"* гэдэг дээр баг дотроо хэлэлцэн нэгдсэн шийдэлд хүрэх.

Алхам 3. Нүүдлээ тайлбарлах ба хамтран хэлэлцэх

- "Нүүдлийн учир шалтгаан" дасгал: Хосоороо тоглох явцдаа нүүдэл хийх бүртээ *"Би яагаад энэ нүүдлийг сонгосон бэ?", "Энэ нүүдэл маань ямар давуу тал бий болгож байгаа вэ?"* гэдгээ өрсөлдөгч, хамтрагчдаа амаар тайлбарлан ярина.
- "Миний шилдэг нүүдэл" танилцуулга: Сурагч өөрийн хийсэн шийдвэрлэх эсвэл бүтээлч нүүдлээ бусад багийнхандаа хөлөг дээр үзүүлэн, сэтгэсэн логикоо тайлбарлан ярина.

Алхам 4. Тоглолтоо эргэн шинжлэх (Анализ хийх)

- "Өрөг сэргээн шинжлэх" хосын ажил: Тоглож дууссаны дараа өргөө эхнээс нь хамтдаа сэргээн нүүж, ямар нүүдэл дээр хожсон эсвэл алдсанаа хамтдаа хайж олно.
- "Алдааны эрэлд" багийн шинжилгээ: Хожигдсон эсвэл тэнцсэн өргийн гол эргэлтийн үеийг (critical moment) хөлөг дээр байрлуулж, алдааг хэрхэн засаж болох байсныг багаараа хайж олно.

Алхам 5. Харилцан санал өгөх ба үнэлэх

- "Нөхөрсөг зөвлөгөө" дасгал: Өрөг дууссаны дараа сурагчид бие биедээ:
 - *"Үүнийг маш сайн хийлээ"* (1 эерэг санал)
 - *"Тэр нүүдэл дээр ингэж нүүсэн бол илүү ашигтай байх байлаа"* (1 сайжруулах санал)-ыг бие биедээ соёлтойгоор хэлнэ.
- Хосын боловсруулсан үнэлгээ: Хосоороо ажиллахдаа бие биенийхээ дүрмийн баримтлал, цаг ашиглалт, тэмдэглэгээ бичилтэд хяналт тавьж, харилцан үнэлгээний хуудас дээр бөглөнө.

Чадвар:

Мэдээлэл ашиглах, асуудал шийдвэрлэх чадвар

- Өгөгдөл, байрлалд шинжилгээ хийх: Хөлөг дээрх өргийн баримт, кейс мэдээллийг (дүрсүүдийн байрлал, хяналт, аюул) ажиглан уншиж, нүүдлийнхээ үндэслэл, нотолгоо болгон тайлбарлах.
- Мэдлэгээ бодит нөхцөлд ашиглах: Шатрын суурь мэдлэгээ ашиглан 1–3 нүүдлийн бодлого бодох, ээдрээтэй тохиолдлыг (байрлалыг) шийдвэрлэж, оновчтой шийдвэр гаргах.
- Загвар баримт татах, харьцуулах: Өмнө нь үзэж судалсан шатрын стандарт өргүүд болон тактикийн загваруудыг өөрийн тоглолтод жишээ болгон ашиглаж, өргийн үр дүнг зөв таамаглах.

Харилцааны болон өөрийгөө илэрхийлэх чадвар

- Нүүдлийн логикоо амаар тайлбарлах: Өөрийн сонгосон нүүдэл, шийдвэрийн учир шалтгаан, санааг хариуцсан хамтрагчдаа эсвэл багийнхандаа ойлгомжтой, дараалалтайгаар амаар тайлбарлах.
- Бичгээр мэдээлэл боловсруулах: Өргийн тэмдэглэгээг алгебрын системээр үнэн зөв бичиж тэмдэглэх, тоглолтын дараах дүн шинжилгээний хуудсыг тодорхой бичиж хөтлөх.

Байр сууриа хамгаалах ба бусдыг хүндэтгэх, багаар ажиллах чадвар

- Үзэл бодлоо хамгаалах ба харилцан суралцах: Байрлалын үнэлгээ хийх болон нүүдэл сонгоход өөрийн үзэл бодол, байр суурийг баримттайгаар хамгаалах, мөн бусдын ялгаатай санаанаас үнэ цэнтэй сайн шийдлийг олж харан тоглолтоо сайжруулах.
- Багийн гишүүн байх ба бусдыг төлөөлөх: "Зөвлөх ба Тоглогч", багийн буухиа тоглолтын үеэр багийнхаа эрх ашгийг нэгт тавьж, хариуцлагатай оролцох, багийг төлөөлөн шийдвэр гаргах.
- Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах: Өрсөлдөгч болон багийн гишүүнийнхээ гаргасан өөр нүүдэл, шийдвэрийг хүлээцтэй хүлээн авч, шүүмжлэлийг эергээр хүлээн авах.

Дүрэм, журам ба дэг, баримтлах зарчим

- Дүрмийг чанд баримтлах: Тоглолтын явцад шатрын холбооны болон тэмцээний дүрэм (барьсан бол нүүнэ, цаг барих, тэмдэглэгээ хөтлөх)-ийг "хууль" хэмээн дээдэлж, чанд мөрдөх.
- Шударга, ёс зүйтэй өрсөлдөх: Ялалт ба ялагдлын үед өрсөлдөгчөө хүндэтгэх, дүрмийн бус үйлдэл гаргахгүй байх, асуудал үүсэхэд дүрмийн дагуу шударгаар шийдвэрлэх зарчмыг баримтлах.